

Дараах баримтуудыг уншаад, юуны тухай болохыг тодорхойлон, бүлэглээрэй.

1. Дэлхийн гадаргын 70-75 хувийг усан бүрхүүл эзэлдэг ч үүний зөвхөн ганцхан хувь нь л цэвэр ус байдаг.
2. Тамхичин хүний ой санамж муудаж, зүрх нь дэлсэн, уушги нь мэнгэртэж, зүс царайгаа алдаж, эрүүл мэндээ аажим аажмаар алддаг.
3. Цэцэг хайр хоёр шиг эмзэг юм ховор. Хэдий чинээ их дурлана төдий чинээ эмзэг хайрын сэтгэлтэй учирна. Энэ л учраас цэцгийг үнсэж үнгэж, илбэж таалж болдоггүй.
4. Дэлхий дээр жил бүр тамхинаас болж ойролцоогоор 7.1 сая хүн нас бардгийн 6.3 сая нь тамхи татдаг хүн, үлдсэн нь дам тамхидалтаас үүдэлтэй.
5. Хайр сэтгэлийг төгс илэрхийлэх үг аль ч хэлэнд байдаггүй. Түүнийг зөвхөн цэцэгсийн хэлээр л илэрхийлж болдог. Хайрлаж, дурлаж үзээгүй хүн тэр хэлийг эс мэднэ.
6. Хүний биеийн усны 2% алдагдахад хүн маш ихээр цангадаг. Цаашлаад 10 хүртэл хувийн шингэнээ алдахад хүн хий юм харж эхэлдэг. 12%-ийн шингэнээ алдсан хүнийг эмчийн тусламжгүйгээр сэхээх боломжгүй болдог бол 20%-ийн шингэнээ алдсан хүн нас бардаг байна.
7. Дэлхий дээр ойролцоогоор 1.5 тэрбум хүн ундны цэвэр усны хангамжгүй амьдарч байна.
8. Дүнсэн тамхинд агуулагдах химийн бодистой харьцуулахад цахилгаан тамхинд цөөн химийн бодис агуулагдах боловч уушгинд хор нөлөөтэй хэвээр ажээ.
9. Цэцэг бол хайрлаж яваа амьтад зориулсан бурхны хишиг. Тиймээс хайр сэтгэлийн өнгийг дагаж цагаан, ягаан, улаан, цэнхэр өнгөөр алаглан найгаж байдаг.

Усны тухай баримтууд	
Тамхины тухай баримтууд	
Хайр сэтгэлийн тухай баримтууд	

